

АМГАЛАН ДУЛААНЫ СТАНЦ ТӨХК-ийн
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ М.МӨНХӨӨ



ШҮТЭЭН УУЛ ХХК-ийн
ЗАХИРАЛ М.АЛТАНЦЭЦЭГ



ХАРУУЛ ХАМГААЛАЛТЫН АЖИЛ ГҮЙЦЭТГЭХ ГЭРЭЭ

20²³ оны 04 р сарын 14 өдөр

Дугаар: 2023 / 23

Улаанбаатар хот

Энэхүү гэрээг нэг талаас Амгалан дулааны станц ТӨХК-ийг төлөөлж Гүйцэтгэх захирал М.Мөнхөө /цаашид захиалагч гэх/ нөгөө талаас Шүтээн уул ХХК-ийг төлөөлж захирал М.Алтанцэцэг /цаашид гүйцэтгэгч гэх/ хамтад нь / цаашид талууд гэх / нар нь Монгол Улсын Иргэний хуулийн 343-358 дугаар зүйл, Төрийн болон Орон нутгийн өмчийн хөрөнгөөр Бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2 дахь заалт, Гэрээт харуул хамгаалалтын тухай хуулийн 8 дугаар зүйл, Амгалан дулааны станц ТӨХК-ийн 2023 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг тус тус үндэслэн дараах нөхцөлөөр харилцан тохиролцож энэхүү гэрээг байгуулав.

Нэг. Гэрээний ерөнхий нөхцөл

1.1 Гэрээний зорилго нь "Харуул хамгаалалтын үйлчилгээ" үзүүлэх ажлыг гүйцэтгэж захиалагч талд ажлын хэвийн үйл ажиллагааг хангаж өгөх. Захиалагч нь гүйцэтгэсэн ажлыг дүгнэж зохих шаардлагыг хангасан гэж үзвэл энэхүү гэрээгээр тохирсон хугацаанд ажлын хөлсийг төлөх, харилцан үүрэг хүлээх, хариуцлагыг тогтоох, харуул хамгаалалтын ажил эхлэх, гүйцэтгэх, дуусах явцтай холбоотой үүссэн харилцааг зохицуулахад оршино.

Хоёр. Гэрээний нөхцөл, хугацаа, ерөнхий зүйл

- 2.1 "Харуул хамгаалалтын үйлчилгээ" үзүүлэх ажлыг 2023 оны 04 дүгээр сарын 13-ны өдрөөс эхлэн 2024 оны 04 дүгээр сарын 13-ны өдрийг дуустал гүйцэтгэнэ.
- 2.2 "Харуул хамгаалалтын үйлчилгээ" үзүүлэх ажлын хугацаа нь гэрээ байгуулагдсан өдрөөс эхэлнэ.
- 2.3 Хоёр тал харилцан тохиролцсоны үндсэн дээр гэрээний гүйцэтгэлийн хугацааг сунгаж болно.

Гурав. Үнэ төлбөрийн нөхцөл

- 3.1 Гэрээт ажлын үнэ нь 82,944,000 /наян хоёр сая есөн зуун дөчин дөрвөн мянга/-н төгрөг бөгөөд үнийн дүнд НӨАТ орсон байна.
- 3.2 Санхүүжилтийг гэрээний баталгаажсан гүйцэтгэлээр хуваарийн дагуу сар бүр төлнө.

| № | Гүйцэтгэсэн байвал зохих ажил | Гэрээгээр тохирсон үнийн дүн сараар | Гэрээгээр тохирсон үнийн дүн | Тайлбар |
|---|--|-------------------------------------|---|---|
| 1 | Гүйцэтгэсэн ажлын хөлсийг сар бүр олгоно | Сард-6,912,000 төгрөг | Нийт 82,944,000 төгрөг /Татвар, Нийгмийн даатгалын шимтгэл орсон/ | Гүйцэтгэсэн ажлын биелэлтэнд сар бүр гүйцэтгэл гаргаж талууд гарын үсэг зурсан байна |
| 2 | Гэрээт харуул хамгаалалтын ажлыг дүгнэх | Гүйцэтгэсэн ажлыг сар бүр дүгнэнэ | Жилийн ажлыг дүгнэнэ | Харуул хамгаалалтын ажлын эцсийн гүйцэтгэл гаргаж, холбогдох баримт бичиг, гэрээг дүгнэж төлбөрийн эцсийн тооцоог хийнэ |

3.3 Гэрээт ажлын төлбөр тооцоог сар бүрийн 30-ны дотор сарын ажлыг дүгнэн баталгаажсанаас хойш нэхэмжлэлийн дагуу 5 /тав/ хоногийн дотор багтаан бодит гүйцэтгэлээр гүйцэтгэгчийн Хаан банкны 5059554411 тоот дансанд тухайн сарын төлбөрийг шилжүүлнэ.

Дөрөв: Захиалагчийн эрх, үүрэг

4.1 Захиалагчийн эрх

- 4.1.1 ХАБ,ААД-ийн шаардлагыг биелүүлэхээс татгалзсан эсэргүүцсэн, дүрэм стандартыг зөрчсөн алдаа дутагдал гаргасан, ажлын хариуцлага алдсан тохиолдолд гэрээг цуцлах хүртэл арга хэмжээг авах эрхтэй.
- 4.1.2 Ажил гүйцэтгэх явцад гүйцэтгэгчийн ажилд захиалагч талаас хяналтыг тогтмол тавьж ажиллана.
- 4.1.3 Харуул хамгаалалттай холбогдсон асуудлаар өөрийн ажилтан болон харуул хамгаалалтын алба хаагчид хууль ёсны шаардлага тавих.
- 4.1.4 Харуул хамгаалалтын алба хаагчийн үйл ажиллагаа, харилцааны соёлд хяналт тавьж, зөрчил дутагдал илэрвэл хамгаалалтын албанд даруй мэдэгдэж, шаардлага тавих.
- 4.1.5 Харуул хамгаалалтын байдал гэрээгээр хүлээсэн үүргийн хэрэгжилтэд хяналт тавих.
- 4.1.6 Хамгаалагч тал хамгаалалтын ажилтны зүгээс гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох талаар тавьсан хууль ёсны санал, шаардлагыг тухай бүр нь хүлээн авч шийдвэрлэх.
- 4.1.7 Хамгаалагч тал гэрээгээр хүлээсэн үүргээ хангалтгүй биелүүлж байгаа тохиолдолд зохих шаардлага тавьж гэрээг цуцлах талаар санал тавих бүрэн эрхтэй.

4.1.8 Хамгаалагч тал гэрээг хэрэгжүүлэх явцад удаа дараа алдаа дутагдал гаргасан тохиолдолд үйлчлүүлэгч тал гэрээг дангаараа цуцлах эрхтэй.

4.2 Захиалагчийн үүрэг

- 4.2.1 Харуул хамгаалалтын алба хаагчийн гүйцэтгэх үүргийг танилцуулж, заавар зөвлөмжөөр хангах.
- 4.2.2 Үйлчилгээ үзүүлэгч /алба хаагч/-д өөрийн байгууллагад гарсан өөрчлөлт хөдөлгөөнийг цаг алдалгүй шуурхай тухай бүр нь мэдэгдэж байх үүрэгтэй. Үүнд:
- 4.2.2.1 Объектод барилгын засвар хийх, тоног төхөөрөмж, овор ихтэй эд хогшлын байршлыг солих.
- 4.2.2.2 Ажлын цагийн хуваарийн өөрчлөлт.
- 4.2.2.3 Объектыг нээх, хаах болон байгууллагын бусад ажилтнууд солигдох /халах чөлөөлөх шинээр томилох гэх мэт/.
- 4.2.2.4 Байрны цонхны бэхэлгээ, гадна, дотор хаалганы цоож, лац, ломбо гэх мэтийг өөрчлөх.
- 4.2.2.5 Хамгаалалтад авагдсан объектын үнэт эдлэл, их хэмжээний мөнгө хадгалах гэх мэт.
- 4.2.3 Хариуцаж байгаа тус объект дээр өдөр тутам тоолж, ширхэгчлэн хүлээж авах боломжгүй байнгын хөдөлгөөнтэй бараа материал хариуцсан тодорхой албан тушаалтантай байх.
- 4.2.4 Гүйцэтгэсэн ажлын хөлсийг сар бүр гэрээнд заасан хугацаанд төлөх үүрэгтэй.
- 4.2.5 Захиалагч тал ажиллах нөхцөл боломжоор хангах үүрэгтэй
- 4.2.6 Үйлчлүүлэгч тал нь өдөр тутам эд хөрөнгө, өрөө тасалгаа, агуулах сав, лац ломбо тавьж, тоног төхөөрөмж бараа материал зэргийг нэг бүрчлэн тоолж биечлэн хүлээлгэн өгнө.
- 4.2.7 Байгууллагынхаа холбогдох ажилтнуудын хаягийн бүртгэл, хамгаалалтанд байгаа объектод байнга нэвтрэх эрх бүхий хүмүүсийн болон эд хөрөнгөтэй харьцах тэдгээрийг захиран зарцуулах эрх бүхий хүмүүсийн нэрсийг өгөх, өөрчлөгдсөн даруй үйлчилгээ үзүүлэгчид мэдэгдэх.
- 4.2.8 Хамгаалалтад авагдсан байр өрөө, тасалгааг цоожтой байлгаж ажлын бус цагаар харуул хамгаалалтын алба хаагчид хүлээлгэн өгнө.
- 4.2.9 Эд хөрөнгө, объектын хамгаалалтанд шаардагдах гал унтраах болон бусад тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл, гэрэлтүүлэгчээр хангах, ажил тарсаны дараа цахилгаан хэрэгслүүдийг хүчдэлээс салгасан байх.
- 4.2.10 Үйлчилгээ үзүүлэгч /хамгаалалтын алба хаагч/-ийн зүгээс гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох талаар тавьсан хууль ёсны санал, шаардлагыг тухай бүрд нь хүлээн авч шийдвэрлэх.
- 4.2.11 Гэмт халдлага, хор аюул учруулж болзошгүй талаар сэжиг бүхий мэдээ мэдээлэл авмагц хамгаалалтын албанд нэн даруй мэдэгдэх, шаардлагатай арга хэмжээг хамтран авах.
- 4.2.12 Хамгаалалтанд өгсөн барилга байгууламж болон тодорхой орчин газарт гадны байгууллагын хамгаалалтын үйлчилгээг давхардуулахгүй байх. Объектод ажлын бус цагаар нэвтрэх эрх бүхий ажилтанг тодорхой гаргаж өгөх.
- 4.2.13 Эд хөрөнгө объектын хамгаалалтын талаар цагдаагийн байгууллагаас тавьсан шаардлагыг биелүүлэх.
- 4.2.14 Мөнгөн тэмдэгт, үнэт зүйлсийг зориулалтын авдар, хайрцагт хадгалах.
- 4.2.15 Хамгаалалтын ажилтны ажиллах нөхцлийг хангах.

Тав: Гүйцэтгэгчийн эрх, үүрэг

5.1 Гүйцэтгэгчийн эрх

- 5.1.1 Хамгаалж байгаа эд хөрөнгө объектын талаар шаардлагатай мэдээлэл авах, түүнд тохирсон онцлог хамгаалалт зохион байгуулах талаар харилцан мэдээлэл солилцон ажиллах.
- 5.1.2 Хамгаалах эд хөрөнгө, объект нь гэрээнд заасан шаардлагыг хангаагүй бол хүлээн авахаас татгалзах.
- 5.1.3 Хариуцаж байгаа тус объект дээр өдөр тутам тоолж, ширхэгчлэн хүлээж авах боломжгүй байнгын хөдөлгөөнтэй бараа материал хүлээн авахгүй байх.
- 5.1.4 Хамгаалж байгаа объектод нэвтрэх хүмүүсийн биеийн байцаалтыг шалгаж нэвтрүүлэх, зөрчил илэрсэн тохиолдолд үйлчлүүлэгч болон холбогдох байгууллага, албан тушаалтанд мэдэгдэх,
- 5.1.5 Харуулууд нь станцын ажилтнуудыг ажилдаа ирж, явахад нь автомашинд нь үзлэг шалгалт хийх гарсан зөрчлийг таслан зогсоох.
- 5.1.6 Хамгаалж байгаа эд хөрөнгийн хадгалалт, хамгаалалтыг сайжруулахтай холбогдсон санал үйлчлүүлэгчид тавих.
- 5.1.7 Хамгаалж байгаа эд хөрөнгө, объект болон өөрт нь шууд заналхийлж зэвсэг хэрэглэсэн, эсхүл бүлэглэн халдсан тохиолдолд харуул хамгаалалтын алба хаагч аргагүй хамгаалалтын хүрээнд зөвшөөрөгдсөн хамгаалах хэрэгслийг хэрэглэнэ.
- 5.1.8 Харуул хамгаалалтын алба хаагчийн тавьсан хууль ёсны шаардлагыг эсэргүүцэнийг хүч хэрэглэхгүйгээр таслан зогсоох боломжгүй бол харуул хамгаалалтын алба хаагч мэх, нэг бүрийн тусгай хэрэгсэл хэрэглэнэ.
- 5.1.9 Ажлын газрын үнэмлэхгүй ажилтныг нэвтрүүлэхгүй.
- 5.1.10 Хууль тогтоомж, гэрээнд заасан бусад эрх.

5.2 Гүйцэтгэгчийн үүрэг

- 5.2.1 Гэрээт ажлыг тендерийн баримт бичигт заагдсан хуваарийн дагуу, тендерт шалгарсан үнэд багтаан батлагдсан графикт хугацаанд, тендерийн баримт бичигт жагсаалтаар ирүүлсэн ажилтнуудаар Харуул хамгаалалтын үйлчилгээг чанартай гүйцэтгүүлнэ.
- 5.2.2 Ажлын хугацаанд гүйцэтгэгчийн талаас ноцтой алдаа дутагдал гаргасан, хөрөнгө дутаасан, хариуцлага алдсан тохиолдолд захиалагч талаас гэрээг цуцлах хүртэл арга хэмжээ авна.
- 5.2.3 Гэрээт ажлыг гүйцэтгэхдээ харуул хамгаалалтын алба хаагчиддаа хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн шаардлагуудыг бүрэн хангуулан, галын аюулаас урьдчилан сэргийлэх бүх талын арга хэмжээг авч ажиллах ба эдгээр шаардлагыг биелүүлээгүй нөхцөлд захиалагч байгууллагын шаардлагаар хамгаалалтын ажлыг зогсооно.
- 5.2.4 Ажил гүйцэтгэх хугацаанд Эрчим хүчний системд мөрдөж буй ТАД, ААД болон Амгалан дулааны станц ТӨХК-ийн хөдөлмөрийн дотоод журам болон холбогдох хууль, тогтоомжийг мөрдөж ажиллана. Захиалагчийн тавьсан шаардлага зөвлөмжийг хүлээн авч заавал биелүүлнэ.

- 5.2.5 Ажил гүйцэтгэж байгаа хамгаалалтын ажилтан нь станцын хашаанд гадны хүн оруулахдаа эрх бүхий албан тушаалтны зөвшөөрөл болох нэвтрэх бичгээр заасан хугацаагаар нэвтрүүлнэ. Мөн объектод орж буй гадны хүмүүсийн биеийн байцаалтыг нэг бүрчлэн үзэж тэмдэглэл хөтлөн, хантааз, дуулга өмсгөж нэвтрүүлнэ.
- 5.2.6 Гүйцэтгэгч тал захиалагчийн зөвшөөрөлгүйгээр гэрээний эрх үүрэг, хариуцлагыг бусдад шилжүүлэхгүй байх үүрэгтэй.
- 5.2.7 Хамгаалалтын ажилтнуудыг албан ёсоор томилж, тэдэнд гэрээнд заасан ажил үүргийг танилцуулсан байна.
- 5.2.8 Объектод хийх ээлжит эргэлт шалгалтыг батлагдсан хуваарийн дагуу хийх.
- 5.2.9 Харуулын байр, хашаа, хаалга орчны цэвэрлэгээ хийх, эд хөрөнгийг нүдээр үзэж хүлээлцэх, ажлын хувцас, цэвэрлэгээ, бичиг хэргийн материал, нэг бүрийн хамгаалах хэрэгсэл зэргээр ажилтнуудаа тогтмол хангах.
- 5.2.10 Хамгаалалтын ажилтан бүр нь бүрэн дунд боловсролоос дээш боловсролтой байх.
- 5.2.11 Гурван постын харуулуудаа хоёр цаг тутам мэргэжлийн удирдлагаар ханган ажиллах, байнга эргэлт шалгалт хийх.
- 5.2.12 Харуул хамгаалалтын алба хаагчийг дүрэмт хувцас, ялгах тэмдэг, нэг бүрийн хамгаалах хэрэгслээр бүрэн хангах, хууль зүйн болон холбогдох сургалтанд хамруулах.
- 5.2.13 Харуул хамгаалалтын алба хаагчаар Гэрээт харуул хамгаалалтын тухай хуулийн 13.1.3-г заасан шаардлага хангасан хүнийг ажиллуулах.
- 5.2.14 Харуул хамгаалалтын алба хаагч нь Гэрээт харуул хамгаалалтын тухай хуулийн 14, 15-р зүйлд заасан эрх, үүргийг хэрэгжүүлнэ.
- 5.2.15 Харуулын байранд согтууруулах ундаа болон мансууруулах бодис хэрэглэх, хүн орогнуулах, тоног төхөөрөмж, бараа материал оруулахыг хориглоно.
- 5.2.16 Алба хаагчид нь ээлж хүлээлцэхдээ хэвийн бус, согтууруулах ундаа хэрэглэсэн байвал ээлж хүлээлцэхийг хориглоно.
- 5.2.17 Алба хаагчид нь ээлжнээс буухдаа тухайн ээлжинд гарсан зөрчил, авсан арга хэмжээ, мэдээллийг харуулын 2,3-р шалган нэвтрүүлэх цэгээс авч 1-р шалган нэвтрүүлэхийн алба хаагч захиалагч талын харуул хамгаалалт хариуцсан ажилтанд танилцуулна.
- 5.2.18 Станцын хашаагаар нэвтэрч байгаа иргэн, ажилтны ажлын үнэмлэхийг шалган, тээврийн хэрэгсэлд үзлэг шалгалтыг тогтмол хийнэ.
- 5.2.19 Алба хаагчид нь станцын ажилтантай үгсэн хуйвалдаж станцын эд хөрөнгийг хулгайлах, бусдад дамжуулахыг хатуу хориглоно.
- 5.2.20 Захиалагч талын “Амгалан дулааны станц ТӨХК-ийн объектод шалган нэвтрүүлэх журам”-ын дагуу ажилтан, иргэдийг нэвтрүүлнэ.
- 5.2.21 Харуул хамгаалалт хариуцсан ажилтанд өдөр бүр ээлж хүлээлцэхдээ мэдээлэл ажлаа танилцуулах.

Зургаа: Талуудын хүлээх үүрэг хариуцлага

- 6.1 Гүйцэтгэгчийн буруугаас ажил үүргээ гүйцэтгээгүй тохиолдолд гэрээнд заасан үнийн дүнгийн 0,1 %-иар хоног тутам гүйцэтгэгч алданги хүлээх ба уг алданги нийт үнийн дүнгийн 10%-иас хэтрэхгүй байна.
- 6.2 Захиалагчийн буруугаас төлбөр төлөх хугацаа хэтэрвэл гэрээнд заасан үнийн дүнгийн 0,1% -ийн алдангийг хоног тутам хүлээх ба нийт үнийн дүнгийн 10% -иас хэтрэхгүй байна.
- 6.3 Гэрээний хугацаанд гүйцэтгэгч тал хариуцсан эд хөрөнгийн эвдрэл гэмтэл гаргавал захиалагч нь мэдсэн өдрөөс хойш гүйцэтгэгчид мэдэгдэж гүйцэтгэгч нь ажлын 3 хоногийн дотор өөрсдийн хөрөнгөөр засч хэвийн ажиллагаанд оруулж хүлээлгэн өгөх үүрэгтэй.
- 6.4 Компанийн дотоод журам, ажлын байранд ёс бус үйл ажиллагаа явуулах согтууруулах ундаа авчирсан, уусан тохиолдолд ажил гүйцэтгэх гэрээг цуцлах ба гүйцэтгэсэн ажлын хөлсийг төлөхөөс татгалзана.
- 6.5 Алданги төлсөн нь үндсэн үүрэг болон учирсан хохирлыг төлөх үүргээс чөлөөлөгдөх үндэслэл болохгүй.
- 6.6 Захиалагчийн саналаар нэмэлт ажил хийлгэх шаардлага гарсан бол тухай бүр хоёр тал харилцан тохиролцож акт протоколоор баталгаажуулж шийдвэрлэнэ.

Долоо: Давагдашгүй хүчин зүйл

- 7.1 Гэнэтийн болон давагдашгүй хүчний шинжтэй нөхцөл байдал гэдэгт үерт автах гал түймэрт нэрвэгдэх, дэлбэрэлтэд өртөх газар хөдлөх, зуд болох, тахал болон байгалийн бусад хүчин зүйлс мөн цэрэг дайны үйл ажиллагаа төрийн эрх барих байгууллагын шийдвэр буюу экспорт импортын хориг ажил хаялт үйлдвэрлэгчийн бүх төрлийн сул зогсолт зэрэг энэ гэрээг зохих ёсоор биелүүлэх боломжгүй байдлыг бий болгохыг ойлгоно.
- 7.2 Гэнэтийн болон давагдашгүй хүчний шинжтэй нөхцөл байдлын улмаас гэрээ биелэгдэх боломжгүй болсон бол талууд бие биедээ нэн даруй мэдэгдэх ба гэрээт хугацаан дээрх нөхцөл байдал арилгах хүртэл хугацаагаар сунгагдах буюу нэг талын санаачлагаар гэрээг цуцална.
- 7.3 Гэнэтийн болон давагдашгүй хүчний шинжтэй нөхцөл байдлыг зохиомлоор буюу болгоомжгүйгээр бий болгосноос бусад тохиолдолд учирсан хохирлыг хариуцах үүргээс талууд чөлөөлөгдөнө.

Найм: Гэрээг цуцлах, нэмэлт өөрчлөлт оруулах

- 8.1 Энэхүү гэрээнд заасан үүргээ талууд ноцтой зөрчсөн буюу хуульд заасан үндэслэл бий болсон бол талууд хэдийд ч гэрээг цуцлах эрхтэй.
- 8.2 Хэрвээ талууд гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулах шаардлага гарвал урьдчилан тохиролцон хавсралтаар оруулж гарын үсэг зурж, тамга дарж баталгаажуулснаар гэрээний нэгэн адил хууль зүйн хүчинтэй.
- 8.3 Хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр цаашид уг ажлыг үргэлжлүүлэх боломжгүй болсон тохиолдолд захиалагчийн санаачлагаар гэрээг цуцлана.

Ес : Бусад зүйл

- 9.1 Энэхүү гэрээний үйлчлэл нь талууд гарын үсэг зурж тамга дарж баталгаажуулснаар хүчин төгөлдөр болж , талууд тус тусын үүргээ биелүүлж гэрээний хугацаа дуусч гэрээг дүгнэж акт үйлдсэнээр гэрээ дуусгавар болно.
- 9.2 Талууд аль нэгнийхээ зөвшөөрөлгүйгээр энэхүү гэрээг гурав дахь талд шилжүүлэхийг хориглоно.
- 9.3 Гэрээг монгол хэл дээр 3 хувь үйлдэж Захиалагч тал 2 хувийг гүйцэтгэгч тал 1 хувийг авах бөгөөд хувиуд ижил тэгш хүчинтэй.
- 9.4 Гэрээнд хоёр тал гарын үсэг зурсан өдрөөс эхэлж гэрээ хүчин төгөлдөр болно.
- 9.5 Энэхүү гэрээнд шууд заагаагүй бусад аливаа асуудлыг Монгол улсын хүчин төгөлдөр мөрдөж байгаа хууль тогтоомжийн дагуу шийдвэрлэнэ.
- 9.6 Захиалагч талаас гэрээний хугацаанд Аж ахуйн ажилтан С.Болд хяналт тавьж ажиллана. Утас-99095047
- 9.7 Гүйцэтгэгч талаас гэрээний хугацаанд Шүтээн уул ХХК-ийн захирал М. Алтанцэцэг хяналт тавьж ажиллана. Утас-99197712.

ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

СЭЗХ-ИЙН ДАРГА
БӨГӨӨД ЕРӨНХИЙ
НЯГТЛАН БОДОГЧ

 Ө.УДВАЛ

АЖ АХУЙ, ХАНГАМЖИЙН
ХЭЛТСИЙН ДАРГА

 Г.БАТТУЛГА

ХЯНАЛТЫН ХЭЛТСИЙН
ДАРГЫГ ХАВСРАН
ГҮЙЦЭТГЭГЧ

 А.ЭНХЖАРГАЛ

ХУУЛИЙН
МЭРГЭЖИЛТЭН

 Г.САРУУЛ


ГЭРЭЭ БОЛОВСРУУЛСАН :
ХАНГАМЖИЙН
МЭРГЭЖИЛТЭН

 Ш.ГАНТУЛГА

Хаяг: Монгол улс, Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, 8-р хороо, УС-15-1-1
Утасны дугаар: 77111251
РД: 6021646

НИЙЛҮҮЛЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

ШҮТЭЭН УУЛ ХХК-ИЙН
ЗАХИРАЛ М.АЛТАНЦЭЦЭГ



Хаяг: УБ хот БГД дүүрэг Чингүүнжавын гудамж 58А 3 давхар офисс
Утасны дугаар: 70140588, 99197712
РД: 2671913